



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ХАХНХ-ИЙН САЙД С.ЭРДЭНЭ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.05.01 № 02/45 ЧАТ/САТ/2014/09/ЦТНА-ДИС

Зөрчил арилгуулах тухай

Нийгмийн даатгалын сангийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ Үүнд:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 30¹ дугаар зүйлийн 1 дүгээр заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 5, 6, 7 дугаар зүйлийн дагуу 1.1 сая даатгагчийн тэтгэврийн нэрийн дансны үлдэгдэл 2012.12.31-нд 6,876,579.2 сая төгрөг байна. Тэтгэврийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 259,020.0 сая төгрөг байна. Гэтэл 1960.01.01-нээс хойш төрсөн иргэд 2015 оноос эхлэн нэрийн данснаасаа тэтгэвэр тооцуулж авах нөхцөл хангагдах бөгөөд тэтгэвэр тогтоолгох даатгагчдын тоо, тэтгэврийн зардлын хэмжээ, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцсон төлөвлөгөө, судалгаа, тооцоолол хангалтгүй хийгдсэн, нэрийн дансны үлдэгдлийг сангийн бодит үлдэгдэлтэй харьцуулбал тэтгэврийн даатгалын сан төлбөрийн чадваргүй болж, хүндэрч болзошгүй байна.


Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль 1999 оноос үйлчилж эхэлсэн боловч өнөөг хүртэл тэтгэврийн нэрийн дансанд бодит хуримтлал үүсээгүй, Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд нэрийн дансны орлого, зарлага, өглөгийг ангилан бүртгэх бэлтгэл болон гүйцэтгэлийн шатны ажлуудыг хийгээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 3.1.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг хэрэгжүүлж тэтгэвэр олгож эхлэхтэй холбогдуулан тэтгэврийн сангийн үйл ажиллагаанд үүсч буй санхүүгийн эх үүсвэрийн хүндрэлээс сэргийлэх тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Дээрх зөрчлүүдийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2014 оны 11 дүгээр сарын 1-ний дотор гаргаж, Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Уртнасан, Бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Батбаатар, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Чулуунчимэг нарт даалгав.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТОР



Л.МӨНХЦАЦРАЛ